

ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС: ТУРШЛАГА, СУРГАМЖ, ЧИГ ХАНДЛАГА

*Ц.Баатар**

Эдийн засгийн глобалчлалын өнөөгийн эринд Монгол Улс дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, үйл явцын өрнөлтөөс хоцрохгүйн тулд өөрийн орны тодорхой бүс нутгуудад гадаадын хөрөнгө оруулалтыг хууль эрхийн актуудаар хөнгөлөлттэй нөхцөл үзүүлэх замаар өөртөө татах бодлого баримталж ирлээ. 1995 онд Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлал”, 2002 оны 6-р сард “Чөлөөт бүсийн тухай ерөнхий хууль”, “Алтанбулаг худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хууль, 2003 оны 6-р сард “Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай” хуулиуд гарч ямар ч гэсэн эрх зүйн орчин бүрдлээ. Үүнээс Алтанбулагийн худалдааны чөлөөт бүсийн мастер төлөвлөгөө гарч, их ажлын эхлэл нэгэнт тавигдлаа. “Замын-Үүд”-ийн эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийг үндэслэн аялал жуулчлал-үйлчилгээний (казиног оролцуулан), худалдааны, үйлдвэрийн гэсэн үндсэн 3 хэлбэрээс бүрдэх “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийг иж бүрнээр нь байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг менежментийн гэрээгээр хэрэгжүүлэх стратегийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер явуулах шийдвэр саяхан гарлаа.

Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллага/ДХБ/-ын бүрэн эрхт гишүүн орны хувьд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын нэн таатай нөхцлөөр “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулах шийдвэр гаргасан нь Монгол болон стратегийн түнш хоёр хөршийн төдийгүй Зүүн хойд Азийн эдийн засгийн интеграцийг нэг алхам ургашлуулахуйц олон улсын ач холбогдолтой чухал үйл явдал боллоо.

Бидний урьдчилан тооцоолсноор эдийн засгийн чөлөөт бүс байгуулснаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг хурдасгах нэгэн хүчирхэг хөдөлгүүр бий болж, гадаад худалдааны эргэлт өнөөгийн түвшингээс даруй 4 дахин, аялал жуулчлал 3 дахин өснө. Ингэснээр ДНБ-ийг 4 дахин нэмэгдүүлэх, боловсролтой залуу үеийнхэнийг 100 хувь ажлаар хангах таатай нөхцөл, боломж бүрдүүлэх юм.

*Ц.Баатар - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

Энэ бүхний үр дүнд Монгол Улсын эдийн засаг бүс нутгийн орнуудын эдийн засгийн хөгжлийн түвшинд дөхөж, Зүүн хойд Азийн бүс нутгийн интеграцид идэвхитэй оролцох түүхэн боломж нээгдэнэ. Ингэснээр Зүүн хойд Азийн худалдааны эргэлтэд бага ч гэсэн зохих хувь хэмжээг эзэлж, энэ бүс нутагт өрнөж эхлээд буй чөлөөт худалдааны гэрээнд нэгдэн орох боломжтой болно гэж өөдрөгөөр төсөөлж байна.

“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн олон улсын ач холбогдол гэвэл Зүүн хойд Ази, Зүүн өмнөд Азийг Европтой холбосон худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлалын нэгдсэн сүлжээ бий болох нэн таатай өргөн боломж нээгдэнэ. Үүний ач үрээр хөрөнгө, валют санхүү, бараа, технологийн дэлхийн солилцоонд Монгол Улс татагдан орох боломж бүрдэнэ.

Монгол Улс түүхэндээ анх удаа эдийн засгийн чөлөөт бүс байгуулах гэж буй энэ цаг үед зарим санаа оноо авахад хэрэг болох болов уу гэсэн үүднээс чөлөөт бүс нээн ажиллуулсан орнуудын хуримтлуулсан туршлага, сургамж, ялангуяа Хятадын эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааны онцлог, улс орны эдийн засагт үзүүлсэн үр нөлөө, Хятадын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлсэн хөнгөлөлтийн талаар тоймлон авч үзлээ.

Дэлхий нийтийн практикаас үзэхэд сүүлийн 20-30 жилд улс орнууд сонгож авсан нутгийнхаа эдийн засгийн хөгжлийг хурдасгах зорилгоор эдийн засгийн болон худалдааны чөлөөт бүсүүд байгуулах болсон байна. Гааль, татвар үл төлөх нөхцлөөр байгуулагдсан анхны чөлөөт бүс өнгөрсөн зууны эцсээр Гданьскад үүсч, ХХ зууны 30-40-өөд онд АНУ болон бусад улсад гаалийн чөлөөт бүсийн тухай хууль гарч, 50-иад оны эцсээр экспортын үйлдвэрлэлийн чөлөөт бүс Ирландын онгоцны буудал Шеннонд байгуулагдаж, 70-80-аад онд энэ талаархи олон улсын хууль тогтоомж ч бий болжээ.

Ийнхүү эдийн засгийн чөлөөт бүс дэлхийн өнцөг булан бүрт түгэн дэлгэрч улс орнуудын эдийн засгийн өсөлт, хөгжлийг хурдасгах нэгэн чухал хүчин зүйл болж иржээ.

UNCTAD-ын мэдээгээр өнөөгийн байдлаар дэлхийн 80 гаруй оронд 900 орчим эдийн засгийн чөлөөт бүс байдаг аж. Түүний 40 гаруй нь Ойрхи Дорнодод, 50 орчим нь Латин Америкт, 80 гаруй нь Европт, 110 орчим нь Мексикт, Хятадад 124, Америкт 213, Азид 225 нь үйл ажиллагаагаа явуулж байна.

Онцлог нутгууддаа хөрөнгө оруулалт, дэд бүтцийг төвлөрүүлэх үүднээс голдуу хөгжиж буй орнууд энэ аргыг түгээмэл хэрэглэдэг

түүнчлэн хөгжингүй орнууд ч өөрийн хоцрогдонгүй бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор ийм бүсүүдийг сонгон байгуулж ашиглах болсон байна. өнгөрсөн арав орчим жилд Зүүн өмнөд Азид (ЗӨА) чөлөөт бүсийн бум буюу өрнөл гэгч боллоо. Ойрмогхоноос шилжилтийн эдийн засагтай орнуудад эдийн засгийн чөлөөт бүс олноор байгуулагдаж байна. /www.FEZ.com/

Түүнчлэн БНХАУ, ОХУ, БНАСАУ хоёртой Түмэн голын сав газраар хил нийлдэг бүс нутгийн байгалийн асар их баялагт түшиглэн энэ нутагт олон улсын эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар 90-ээд оны эхээр тохиролцсон билээ. Гурван улсын энэ санаачлагыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр сайшаан дэмжиж уг асуудлыг урагшлуулахад түлхэц нөлөө үзүүлэх гэж чармайж байгаа хэдий ч Хятадаас өөр хүчин чармайлт тавьдаг орон одоо хэр алга байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс «Түмэн гол нутгийг хөгжүүлэх хөтөлбөр» (ТГНХХ) нэртэй урт хугацаанд хэрэгжүүлэх асар том төсөл боловсруулсан бөгөөд түүнд урьдчилсан тооцоогоор 30 тэрбум ам.долларын зардал шаардагдах юм. Энэхүү хөтөлбөр нь «Түмэн голын эдийн засгийн бүс» (Хуньчин-Посьет-Ражин) ба «Түмэнгийн эдийн засгийн хөгжлийн бүс» (Тяньжин-Владивосток-Чонжин) гэсэн хоёр бүсийг юуны өмнө өөртөө багтаахаар төлөвлөгдөж байгаа аж. Энэ ажлын явц Солонгосын хойгийн байдал болон бусад олон шалтгааны улмаас өнөө хэр дорвитой үр дүнд хүрээгүй байна. Одоо эдийн засгийн чөлөөт бүс, түүний төрлүүдийн талаар авч үзье.

Эдийн засгийн чөлөөт бүс, түүний төрөл хэлбэрүүд, давуу болон сул талууд, туршлага сургамж

Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг тодорхой төрлүүдэд хуваан авч үздэг. Орчин үед хөгжиж байгаа орнууд, хөгжингүй орнууд ялгаагүй эдийн засгийн чөлөөт бүсийг дэд бүтцийн хөгжлийг төвлөрүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтаар түлхэц өгөх хэрэгсэл болгон ашиглах нь нийтлэг болсон байна. Тусгайлан гаргасан нутаг дэвсгэрийн хэрэгцээнд илүү сайн тохирохуйц, эдийн засгийн чөлөөт бүсийн төрлийг сонгон авах явдал нь олон хүчин зүйлээс хамаардаг байна. Тэдгээр хүчин зүйл нь газар нутгийн байршил, одоо байгаа, цаашдаа бүрдэх бололцоотой дэд бүтцийн хөгжил, үйлдвэржүүлэлтийн төвшин ба үйлчилгээ, хууль эрх зүйн (хэв журмын) тогтолцоо зэргээс бүрддэг. Эдийн засгийн чөлөөт бүсүүдийг дараах төрлүүд болгон бүлэглэж, тодорхой район, улсаар төлөөлүүлэн авч үздэг байна. Үүнд:

1. Чөлөөт боомт - худалдааны чөлөөт бүс (Гонконг, Сингапур).

Энэ төрлийн бүс нь өндөр хөгжсөн жижиг оронд бий болж гадаад том зах зээлээр хүрээлэгдэж байдгаар өвөрмөц юм. Тэнд импорт, экспортын татвар хамгийн бага буюу огт үгүй, чамгүй зүгширсэн үйлчилгээний салбартай. Энэ салбар нь ачих буулгах үйлчилгээ, банк, даатгал зэрэг олон улсын бизнесийн арилжааг дэмжих чадвартай байдгаараа онцлогтой.

2. Эдийн засгийн чөлөөт бүс (Шэньжен Батам). Энэ бүс асар том Хятад, Индонези улсын нутаг дээр байгуулагдсан учир энд тогтоосон хөнгөлөлттэй (преференциал) татвар, түлхэц үзүүлэх бусад хүчин зүйл нь бүс нутгийн хөгжлийг урагшлуулах баталгаа болдог. Бүсэд үйлдвэрлэлийг явуулахад мэргэжлийн үйлчилгээ чухал үр нөлөө үзүүлдэг байна.

3. Экспортын үйл явцыг эрхэлдэг бүс (Өмнөд Солонгос, Тайвань, АСЕАН). Ийм бүсүүдийн онцлог нь мэргэжилтэй ажилчдаар сайтар хангагдсан нутагт оршдог бөгөөд экспортын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд хэрэгцээтэй зүйлсийг татваргүйгээр оруулахыг зөвшөөрдөг байна.

4. Худалдааны чөлөөт бүс (Панам, Абу Даби). Зам харилцааны гол зангилаа газар, үндсэн зах зээлийн ойролцоо оршдог энэ бусад реэкспортод зориулагдсан бүх барааг татвараас чөлөөлж, чөлөөтэй оруулахыг зөвшөөрдөг байна.

5. Импортын үйл явцыг эрхэлдэг бүс (АНУ). Хожим үйлдвэрлэл явуулахад ашигладаг бүх материалыг эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах зорилгоор гаднаас оруулж буй түүхий эдийг татвараас чөлөөлдөг байна. Ийм төрлийн бүсүүд нь өргөн дэлгэр нутаг хамарсан, гол гол зах зээл бүхий АНУ-ын хэд хэдэн муж улсад байгуулагджээ. Ийм төрлийн бүсийнхэнд их хэмжээгээр бараа оруулж, тээврийн хөлсийг бууруулж, үйлдвэрлэсэн бүх барааг эцэслэн зарах хүртэл гаалийн татварын төлбөрийг хойшлуулах бололцоо олгодог ажээ.

6. Импорт, экспортын үйл явцыг эрхэлдэг бүс (Хятад, АСЕАН). Энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг бүсүүдэд оруулж байгаа бүх барааг татвараас чөлөөлнө. Бүсээс экспортонд гаргах барааны нэр төрлийг олшруулах, энэ үйл ажиллагааг төвлөрүүлэх зорилгоор ийм стратегийг ашигладаг байна.

Дээр дурдсан зургаан төрөлд хувааж болох эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай ажиллуулахад зайлшгүй шаардагдах тодорхой нөхцөл

бүрдүүлж, тодорхой зорилго тавьдаг. Чөлөөт бүс байгуулахад дараах хүчин зүйлс зайлшгүй шаардагддаг байна.

- Эдийн засгийн чөлөөт бүсийн талаар төр засгийн газраас явуулах ил тод бодлого
- Засгийн газраас байгуулсан дэд бүтэц
- Гааль, ачих буулгах зэрэг үйлчилгээний зүгширсэн тогтолцоо
- Өрсөлдөөний үндсэн дээр цалинждаг мэргэжлийн ба мэргэжлийн бус ажиллах хүч.
- Банк, даатгал зэрэг үйлчилгээний салбар
- Ажиллахаар шилжин ирэгсдэд зориулан сайн чанарын орон сууц, тав тухтай орчин, аюулгүй байдал болон бусад зүйл
- Эдийн засаг, улс төрийн тогтвортой байдал
- Хууль эрх зүйн зүгширсэн тогтолцоо

Эдгээр хүчин зүйлсээс нэг буюу хэд хэдэн нь дутагдвал эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагааг хойш татна. Жишээ нь Индонезийн Батам аралд дэд бүтэц хангалтгүй. Шри-Ланкийн Колумбод улстөрийн байдал тогтворгүй, Дорнод Малайзид ажиллах хүчин дутагдалтай, Төв Индонезид үйлчилгээний салбар сул хөгжилтэй байснаас болж тэдгээр нутагт байгуулсан чөлөөт бүсүүд тухайн үедээ олигтой ажиллахгүй байсан ажээ.

Эдийн засгийн чөлөөт бүсийн зорилго нь янз бүрийн улсын хооронд төдийгүй, нэг улсын бүс нутгийн хооронд өөр өөр байж болдог байна. Нийтлэг гол зорилгуудаас дараа дурдсан хэдийг онцолж болно. Үүнд:

- Бүс нутгийн хөгжлийг хүчтэй болгох,
- Гадаадын хөрөнгө оруулалтанд түлхэц үзүүлэх,
- Шинэ технологийг нэвтрүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх,
- Дэд бүтцийг хөгжүүлэх ажиллах хүчний мэргэшлийг өндөржүүлэх,
- Эдийн засгийн шинэ системийг туршиж үзэх гэх зэрэг болно.

Амжилттай ажиллаж байгаа эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг Тайвань, Сингапурийн жишээн дээр товч дурдъя. Тайвань бол экспортын үйл явцыг эрхлэх бүсийг амжилттай ашигласан анхны орнуудын нэг юм. Дурьдсан чөлөөт бүсийг шинэ үйлдвэрүүдийг байгуулах хэрэгсэл болгон ашиглаж ажлын байруудыг бий болгох, экспортоос гадна солилцооны ашиг олох талаар үр дүнд хүрчээ. Тайваньд анхны экспортын үйл явцыг эрхлэх бүсийг 1966 онд Такаоод,

1971 онд Нанко, Дайчуд байгуулжээ. Тайваний эдгээр бүс нь 174 гектар газарт байрладаг, 70 мянган хүн ажилладаг юм байна.

Тайвань эдгээр бүсийг байгуулахдаа хэд хэдэн зорилго тавьсан байна. Эдгээр нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтад тус дөхөм үзүүлэх; экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг хөгжүүлэх; ажлын байр бий болгох; шинэ технологийг нэвтрүүлэх явдал байв. Бүсүүдэд компаниудын анхаарлыг хандуулан татахын тулд Тайвань гаалийн татвар, хэрэглээний татвар, корпорациудийн ашиг орлогын татвараас эдгээр компанийг чөлөөлөх аргыг сонгон авчээ. Үүний үр дүнд бүсүүдэд нарийн машин, электроник, пластикийн үйлдвэрлэл зэргийг багтаасан 270 гаруй үйлдвэр ажиллах болжээ. Туршилтын эхэн үед экспортын үйл явцыг эрхлэн чөлөөт бүсүүд Тайванийн нийт экспортоос олсон мөнгөний дийлэнх хэсгийг өгч байлаа. 1967-1976 оны хооронд бүсүүд 2,3 тэрбум ам.долларын экспортын бүтээгдэхүүн буюу Тайванийн бүх экспортын 70 хувийг гаргаж байжээ.

Зүүн өмнөд Азийн бүс нутгийн төвүүдийн нэг болсон Сингапурын хөгжил нь голдуу гадаад хөрөнгө оруулалтаар нөхцөлдсөн байна. Энэхүү хот улс нь дотооддоо тодорхой арга хэмжээ авч явуулан, татвар, хураамжийн доогуур түвшнийг тогтоох, үйлдвэрлэл, худалдаа, ачих буулгах үйлчилгээ; санхүүгийн салбарт өрсөлдөөний нөхцөлд ажиллаж чадсанаар ийнхүү эдийн засгийн чөлөөт бүс богино хугацаанд амжилттай хөгжиж чаджээ. Сингапурт дэд бүтцийг байнга боловсронгуй болгож, үйлчилгээний зардлыг бүс нутгийн бусад орныхоос харьцангуй доогуур тогтоосон байна. 1985 оноос Сингапур урамшуулал, хөнгөлөлтийг зохион бүтээх туршилтын шийдлийг хөхүүлэн дэмжих, дотоодод гүн боловсруулалтыг нэвтрүүлэх замаар өндөр ашиг өгөх үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн болон бусад үйлчилгээ өөд тэмүүлэх хөдөлгөөнийг дэмжих талаар онцгой хүчин чармайлт тавьсан байна. Энэ бүхэн нь гадаад хөрөнгө оруулалтын өндөр түвшингийн үр дүн бөгөөд тэдгээр улс орны онцгой ашигтай газар нутгийн байршил, онгоцны буудал их нэмэр болжээ.

Дээр дурдсан гурван улсын жишээнээс гадна Гонконг, Өмнөд Солонгос, Тайланд, Малайзи, Индонез зэрэг орон эдийн засгийн чөлөөт бүсийн үзэл баримтлалыг өөр өөрийн нөхцөлд тохируулан амжилттай хэрэгжүүлсэн байна.

Одоо эндээс тусгайлан ОХУ, БНХАУ-д байгуулагдсан эдийн засгийн чөлөөт бүсийн талаар нэлээд тодорхой авч үзье.

Оросын Холбооны Улс

1990 онд эдийн засгийн чөлөөт бүс 11-ийг тодорхойлон гаргаж энэ үйл ажиллагааг бүх орон даяараа дэлгэрүүлэх чиг баримталж ирлээ. 11 чөлөөт бүсийн 4 нь Оросын Алс Дорнодод тухайлбал Чита, Сахалин мужууд, Приморын хязгаар, Еврейн автономит мужид байдаг ажээ. Приморийн хязгаарын засаг захиргаа «Их Владивостокийн эдийн засгийн чөлөөт бүс»-ийн (Находка хотын районыг өөртөө багтаасан) үйл ажиллагааг өрнүүлэхэд анхаарал тавьж байна. Энэ чөлөөт бүс нь Приморийн хязгаарын өмнөд хэсэгт орших бөгөөд дорнод талдаа Восточный боомт, өрнөд талдаа Хасан нуур хүрч, Умард Солонгос, Хятадтай хиллэдэг өргөн их нутаг дэвсгэрийг хамарч байгаа юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ивээл дор Японы техникийн зөвлөх пүүсүүдийн холбооноос энд судалгааг 90-ээд оны эхээр явуулжээ. «Их Владивостокийн эдийн засгийн чөлөөт бүсийн» (ИВЭЗЧБ) зорилго нь Ази тивийн орнуудтай худалдаа хийх, тэднээс хөрөнгө оруулах явдал юм. ИВЭЗЧБ нь импорт, экспортын үйл явцын аль алиныг эрхлэх бүс бөгөөд далайн чөлөөт боомт, олон төрлийн үйлчилгээний баазад тулгуурлан ажиллах юм. Тус бүс нь 3 дэд бүстэй, боловсрол, эрдэм шинжилгээ, үйлчилгээ бүхий бүсийн төв штаб байрлах Владивосток хот; өргөн масштабтай, эрчимтэй үйлдвэрлэлийг дагнан эрхлэн Находка хот; их ач холбогдолтой дэд бүтэц, тээврийн сүлжээ байхгүй боловч аж үйлдвэр, хөдөө аж ахуй, загас агнуур, хүнсний үйлдвэрлэлийг хил залгаа Хятад, Умард Солонгостой хоршин явуулж болох давуу талтай Хэсан хотоос тус тус бүрддэг.

ИВЭЗЧБ-ийн хөгжил нь 3 шаттай хэрэгжихээр тооцоологдсоны I шатанд, байгаа нөөцдөө түшиглэсэн үйлдвэрлэл явуулж бүтээгдэхүүнээ хилийн чанадад борлуулан, өөрийн дэд бүтцэд хэрэгтэй зүйлсийг оруулах; II шатанд, экспортын эрэлт ихтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, импортоос хамаарах хамаарлыг багасган, барааны чанарыг дээшлүүлэх олон улсын стандартад ойртуулах; III шатанд, дотоодод хэрэглэх, экспортод гаргах бүтээгдэхүүний аль алины үйлдвэрлэлийг өндөр технологийн түвшинд хүргэн дээшлүүлэх зорилтуудыг шийдвэрлэхээр төлөвлөжээ.

Хөрөнгө оруулагчдад үзүүлэх инсентивүүд нь төдий л оновчтой бус, дотоод гадаад орчны олон хүчин зүйлсээс хамааран эдгээр эдийн засгийн чөлөөт бүсүүд хөрш Хятад улсын чөлөөт бүсүүдээс хамаагүй сул, бараг эхлэлтийн шатандаа явна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятад улс анх 1979 онд өмнөд нутгийн Гуандун, Фузянь мужид эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар уян хатан онцгой бодлого явуулах эрх олгосноор энэ хоёр муж Хятадад улсын анхны эдийн засгийн чөлөөт бүс нутаг болсон түүхтэй. 1980 онд энэ 2 мужийг түшиглэн Шэньжень, Жухай, Шаньтоу /Гуандун муж/, Сямынь /Фузянь муж/ гэсэн эдийн засгийн 4 чөлөөт бүс байгуулжээ.

БНХАУ-ын Шэньжений эдийн засгийн чөлөөт бүс нь дэлхийн хамгийн амжилттай ажиллаж буй бүсүүдийн нэгд тооцогддог. Яагаад гэвэл энэ бүс нь хөрөнгө оруулалтыг үйлдвэрлэлийн салбараар хязгаарлаагүй, худалдаа, аялал жуулчлал, үйлчилгээ /казиног оролцуулан/, үл хөдлөх хөрөнгийн салбарыг хөгжүүлэхэд нийтийн анхаарлыг татаж чадсан ажээ. Энэ бүс нь Хятадад зөвшөөрөгдсөн зах зээлийн эдийн засгийн зарчмуудыг хэрэглэх туршилтыг явуулах, цаашид энэ туршилтын үр дүнг улс орны бусад муж, районд дэлгэрүүлэхэд үйлчлэх зорилгоор байгуулагдсан бөгөөд энэ зорилгоо амжилттай хэрэгжүүлсэн билээ.

Шэньжений бүсийг 1980 онд 327,5 хавтгай дөрвөлжин километр нутаг дээр байгуулсан бөгөөд 1990 он хүртэлх 10 жилд 512 сая долларын өртөгтэй хөрөнгө оруулалтын 569 төслийг өөртөө татаж чадаад 476 мянган ажлын байрыг буй болгожээ. 1990 онд энэхүү бүсэд 5 тэрбум ам.долларын экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Далайн чанадад оршин суудаг хятад хүмүүс эх орныхоо эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад Шэньжень үйлчлэх зорилготой байсан, түүнээ ч амжилттай биелүүлж байгаа ажээ.

Чөлөөт бүсийн талбайн хувьд хамгийн том нь Шэньжэн 327,5 ам дөрвөлжин км бөгөөд бусад нь нэг их биш. Тухайлбал, Жухай 6,7, Шаньтоу 1,67, Сямынь 2,5, ам дөрвөлжин км юм. Эндээс үзвэл эдийн засгийн чөлөөт бүсийн талбай нь Гуандун мужийн нутаг дэвсгэрийн 16 хувь, Фузянийн нутаг дэвсгэрийн тун ялихгүй хувийг эзэлж байна. 1983-1985 онд чөлөөт бүсүүдийн талбайг өргөтгөж Жухайг 15,16, Шаньтоуг 52, Сямынийг 131 ам дөрвөлжин км болтол өргөтгөн тэлж өгчээ.

Хятадын Засгийн газраас чөлөөт бүсийн дотоод асуудалд оролцохоос зайлсхийж бие даалгах зарчим баримталж иржээ. Эхний үед чөлөөт бүсийн удирдлагыг төвөөс томилж байснаа больж орон нутагт нь хариуцуулсан байна. Төвөөс эхний 5 жилд татвараас бүрэн чөлөөлж, үйлдвэрлэлийн хэрэгслийн үйлдвэрлэлд төрөөс зээл олгож, хөрөнгө оруулагчдаас тухайн жилд чөлөөт бүсийг хөгжүүлэх санд

төвлөрүүлсэн байх мөнгөний доод хэмжээг тогтоож өгдөг байжээ. Хятадын Засгийн газраас дараахи инсентивүүдийг хөрөнгө оруулагчидад олгож иржээ. Үүнд:

- Хамтарсан хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн хувьд хөрөнгө оруулалтаа нөхсөний дараахи үйлдвэрийн орлогын татварыг 15 %-иар тогтоож өгчээ. Тэгвэл хамтарсан хөрөнгө оруулалттай чөлөөт бүсийн гадна үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрүүдийн хувьд орлогын татвар 33%, улсын үйлдвэрийн орлогын татвар 55 % байдаг аж;
- Улсаас нэн хөнгөлттэй нөхцлөөр зээл олгож, зарим нэн чухал ач холбогдолтой объектод төрөөс татаас олгож, үндсэн хөрөнгийн хурдацтай элэгдлийг хүлээн зөвшөөрч, хөрөнгө оруулалт, дахин хөрөнгө оруулалт хийхэд нэн таатай хөнгөлтүүд үзүүлсэн ;
- Чөлөөт бүсэд их барилгад хөрөнгө оруулалт хийхэд хүнд аж үйлдвэрт 50 сая, хөнгөн үйлдвэрт 30 сая юаний барилга байгууламжийг төв засгийн зөвшөөрөл авалгүйгээр барих зөвшөөрөл олгосон;
- Цахилгаан эрчим хүч, усны хангамж, газрын түрээсийн хувьд хөрөнгө оруулагчийг татахуйц инсентив үзүүлсэн;
- Газрын түрээсийн төлбөрийн хэмжээний хувьд барилга байгууламжийн шинж байдал, ач холбогдлыг нь харгалзан ялгавартай тогтоож өгсөн;
- Шинэ өндөр технологийн болон үндэстэн дамнасан корпорацуудын дэлхийн нэрд гарсан бүтээгдэхүүн, түүний эд ангийн нэг хэсгийг үйлдвэрлэдэг техник, технологиор төхөөрөмжлөгдсөн бол газрын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн;
- Чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, нийлүүлэгчидтэй шууд харилцах, ажилтнуудын цалингийн доод хэмжээг тогтоох, ажилтан авах, халах эрхийг чөлөөт бүсийн үйлдвэрүүдэд олгосон;
- Оюуны болон менежментийн өндөр ур чадвартай мэрэгжилтнүүдийг гаднаас урьж ажиллуулах боломж олгосон;
- Үйлдвэрийн газрын татварын дараахи ашгийг гадагш чөлөөтэй шилжүүлэх эрх олгосон;
- Чөлөөт бүсэд зориулан гаднаас оруулах бүтээгдэхүүнд болон экспортлох бүтээгдэхүүнийг гаалийн татвараас бүрэн чөлөөлөх буюу нэн хөнгөлөлттэй нөхцөл олгосон зэрэг болно.

Дээрхи багц инсентивүүд нь экспортын чиг баримжаатай үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалыг нэгэн зэрэг хөгжүүлэхэд ихээхэн тус дөхөм үзүүлжээ. Түүнчлэн чөлөөт бүсэд хөрөнгө оруулагчдад гарааны нөхцлөөс эхлэн цогцолбор шинжтэй хөрөнгө оруулалт хийх боломж олгож богино хугацаанд ихээхэн хэмжээний хөрөнгө, мөнгийг татан төвлөрүүлж чаджээ. Чөлөөт бүсэд Хятадын уламжлалт төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс үлэмж ялгаатай эдийн засгийн шинэ бүтэц бүрэлдэн бий болсон байна.

Чөлөөт бүсэд авч хэрэгжүүлсэн удирдлага, зохион байгуулалт, аж ахуйн үйл ажиллагааны шинэ арга хэлбэр, барууны менежмент, хөвөгч үнэ ханшийн бодлого зэрэг нь Хятад улсын эдийн засгийн шинэтгэлийн үйл явцад хүчтэй түлхэц өгсөн гэж судлаачид үздэг.

Чөлөөт бүсэд Хятадын уламжлалт төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн системээс үлэмж ялгаатай эдийн засгийн шинэ бүтэц бүрэлдэн бий болсон байна. Нэг улсад хоёр систем ийнхүү амжилттай үйлчилж эхэлсэн байна.

Хятад улс эдийн засгийн чөлөөт бүсийн талаар туршлага хуримтлуулж сургамж авахын хэрээр тэдгээрийг дагнах, төрөлжүүлэх хэлбэрээр хөгжүүлэх болсон байна. Тухайлбал, Шэнжаны чөлөөт бүс нь аялал жуулчлал, олон улсын худалдаа, боловсруулах өндөр технологийн үйлдвэр, хүний нөөцийг хөгжүүлэх зэрэг хөгжлийн цогц шинж чанараараа онцлогтой. Жухай хүнсний үйлдвэр, аялал жуулчлал, худалдааг хөгжүүлэх чиглэл баримтлах болжээ. Шаньтоу хөнгөн хүнсний аж үйлдвэрээр, Сямынь жуулчлал, үндэстэн дамнасан корпорацийн өндөр технологийн бүтээгдэхүүнийг угсрах, электроник, мэдээллийн технологийн чиглэлээр дагнах болсон байна.

1985 оноос эхлэн чөлөөт бүсэд явуулах бодлогоо аажмаар өөрчилж экспортод чиглэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг давамгайлан хөгжүүлэх чиглэл баримтлах болжээ. Тухайлбал чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 60-аас доошгүй хувийг экспортлосон байх үүргийг үйлдвэрийн газрууд өөртөө хүлээх болсон. 70% хүрсэн бол орлогын татварыг 10% болгох, түүнээс дээш бол улам бүр багасгах, чөлөөлөх урамшуулал үзүүлэх болжээ. Экспортын чиглэлийн хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдэд улсаас юаниар болон хатуу валютаар ихээхэн хэмжээний хөнгөлөлттэй зээл олгох болсон байна.

1988 оноос эхлэн чөлөөт бүсийн хөгжлийн хоёрдахь шат эхэлсэн гэж үздэг. Энэ үеэс эхэлж Хятад улс эдийн засгийн чөлөөт бүс, нээлттэй хот байгуулах стратегиэ өөрчилж тэнгисийн эрэг хавийн хот, хошуудыг

нэгтгэж газар нутгийнхаа хэмжээг тэлэн өргөтгөж, өндөр хөгжилтэй орнуудын шинэ техник, технологи шилжүүлэн авах, зээлдэх, тэдний ноу хауг олж авах тал дээр түлхүү анхаарч эхэлсэн. Энэ үндсэн дээр экспортын зориулалттай эзэмшлийн бүс хэмээх стратегид шилжсэн байна.

Эдийн засгийн чөлөөт бүс, эзэмшлийн бүс хоёрын зарчмын ялгаа нь засаг захиргааны статус, удирдлага зохион байгуулалтын онцлогт байгаа юм. Эзэмшлийн бүсүүд нь өөрийн гэсэн засаг захиргааны нутаг дэвсгэргүй байдаг. Эзэмшлийн бүсүүдийг тэнгисийн эргийн нээлттэй хотуудын орон нутгийн байгууллагууд шууд удирддаг.

1990-ээд оноос Хятадын зүүн хойд хэсгийн эдийн засгийн чөлөөт бүсийн статустай нээлттэй хот хилийн болон хил орчмын районуудад өрнөн дэлгэрсэн юм.

1992 онд зүүн хойт хил хавийн Хэйхэ, Суйфынхэ /Хэйлунжан/, Чунчун /Жилин муж/, Манжоули /Өвөр Монгол/ гэсэн 4 хотыг нээлттэй хот болгов. Энэ үндсэн дээр “Хил хавийн хамтын ажиллагаа”-ны 4 том бүс байгуулагдсан. Эдгээрт:

- Чита муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орны хамтын ажиллагааны үндсэн дээр байгуулагдсан Забайкальск-Манжоули
- Амур муж, Хэйлунжань мужийн хамтын ажиллагааны үндсэн дээр байгуулагдсан Благовещенск-Хэйхэ
- Приморийн хязгаар, Хэйлунжан мужийн хамтын ажиллагааны үндсэн дээр байгуулагдсан Пограничный-Суйфынхэ
- Приморийн хязгаар, Хэйлунжан мужийн хамтын ажиллагааны үндсэн дээр байгуулагдсан Краскино-Хуньчунь гэсэн бүсүүд орж байна.

Мөн онд Оростой хил залгаа 9 районы 40000 ам дөрвөлжин км нутгийг нээлттэй болгожээ. Хэдэн жилийн өмнө Монгол Улсын хил залгаа Эрээн хотыг ч мөн л нээлттэй хотоор зарлаж баруун хилийн сувдан сондор болгох зорилт тавьсан билээ.

1990-ээд оны сүүлчээр оюуны багтаамж шаардсан өндөр технологи, шинэ техникийг үйлдвэрлэлийн аргаар эзэмших, мэдээллийн технологийн Америкийн Сликаны хөндий маягийн үйлдвэрлэлийн парк буюу эдийн засаг, техникийн хөгжлийн чөлөөт бүс байгуулахад ихээхэн анхаарал тавих болов.

Хятад улс 2000 оноос эдийн засгийн чөлөөт бүс, нээлттэй хот, эзэмшлийн бүсийн загварыг баруун бүс нутгаа хөгжүүлэх стратеги зорилгоо хэрэгжүүлэхдээ чадамгай ашиглаж байна.

Ийнхүү Хятад улс эдийн засгийн чөлөөт бүс болон нутаг дэвсгэрийн нээлттэй байдлын олон хэлбэрийг чадамгай хосолж гадаадын хөрөнгийн их урсгалыг өөртөө гүр соронзон мэт татан төвлөрүүлэх талаар асар их туршлага хуримтлуулж, дэлхий нийтийн чихийг дэлдийлгэсэн эдийн засгийн өсөлт, хөгжлийн өнөөгийн гайхамшигт өндөрлөгт хүрч чаджээ.

Гадаадын хөрөнгө оруулагчдыг өөртөө татах Хятадын стратеги нь хэдийгээр хэн ч маргаж үл чадах асар их өргөн боломжийн зэрэгцээ зарим бэрхшээл, сөрөг үр дагавар авч ирсэн болохыг энд тодорхой дурдах нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь Монгол шиг жижигхэн эдийн засагтай, жижиг орны хувьд анхаарч үзүүштэй сургамж ч байж болохыг үгүйсгэхгүй.

Ямар ямар сөрөг үр дагавар авч ирсэн бэ гэвэл, нэгдүгээрт, чөлөөт бүс, эзэмшлийн бүс, нээлттэй хотуудыг хэт хавтгайруулснаас хяналт алдагдсан, элдэв хэрэг зөрчил ихэссэн, татварын онцгой эрх дарх эдлэгчдийн хүрээ асар их тэлэн өргөжсөн. Судлаачид үүнийг “ёроолгүй торх” хэмээн нэрлэх болжээ. Хоёрдугаарт, чөлөөт бүсэд нутаг дэвсгэрийн өргөн дэмжлэг олгож байсан нь экологийн хувьд зарим сөрөг үр дагавар авч ирсэн. Үүнээс үүдэн сүүлийн үед нутаг дэвсгэрийн дэмжлэг үзүүлэхээ больж тэргүүлэх үйлдвэрлэлийн салбарын өндөр технологийн үйлдвэрийн парк байгуулахад л газар ашиглуулах болжээ. Гуравдугаарт, татварын онцгой хөнгөлөлт хэт хавтгайрсан учир төсөвт төвлөрүүлэх мөнгөний хэмжээ буурсан. Урьд нь орлогын татварын хэмжээ бүс нутгийн зэрэглэл, бусад олон хүчин зүйлсээс хамааран хэлбэлзэлтэй тогтоодог байсныг өөрчилж одоо өмчийн бүх хэлбэрийн үйлдвэрийн газруудын орлогын татварыг нийтэд нь тэгшитгэж 33% болгожээ. Дөрөвдүгээрт, ямар ч хамаагүй үнээр “бичил бүс” байгуулах гэсэн өвчин газар авсан байна. 90-ээд онд 8700 орчим ийм “бичил бүс” байгуулагдаж чөлөөт бүсээс ч илүү эрх дарх эдэлж байжээ. Судлаачид үүнийг “Бүсийн чичрэг өвчин” гэж нэрлэсэн. Дэд бүтэц хөгжүүлэх хөрөнгө мөнгөгүй, зөвшөөрөлгүй, зөрчилтэй, үр ашиггүй, үржил шимтэй газрыг дур мэдэн ашигласан гэсэн үндэслэлүүдээр 1000 гаруй бүсийн үйл ажиллагааг хоригложээ. Хятад улс цаашдаа Зүүн өмнөд, Зүүн хойд хэсэгтээ чөлөөт бүс нэмэхгүй гэсэн чиг баримтлаж байна. Хятадын чөлөөт бүсийн үйл ажиллагааны тухай хураангуйлан өгүүлэхэд ийм байна.

ДҮГНЭЛТ

Эдийн засгийн чөлөөт бүсийг амжилттай хөгжүүлсэн орнуудын туршлагаас үзэхэд орон тус бүр өөр өөрийн онцлог, өвөрмөц байдалд зохицсон, стратегийн ач холбогдол өгсөн бүс нутагтаа эдийн засгийн чөлөөт бүсийн статус олгож дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтад тус дөхөм үзүүлэх; экспортод чиглэсэн үйлдвэрүүдийг хөгжүүлэх; ажлын байр бий болгох; шинэ технологийг нэвтрүүлэх, улс орны хөгжилд түлхэц өгөх, эдийн засгийн гадаад харилцааг өргөтгөх чиглэлд голлон анхаардаг байна. Чөлөөт бүсүүдэд гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татахын тулд уян хатан инсентивийн бодлого баримталж, гаалийн татвар, хэрэглээний татвар, корпорацын ашиг орлогын татвараас гадаадын хөрөнгө оруулагчдыг чөлөөлөх инсентивийг гол төлөв сонгон авдаг аж. үүний үр дүнд бүсүүдэд нарийн машин, электроник, жижиг хэсгийг дагнан үйлдвэрлэх, өндөр болон мэдээллийн технологийн бүтээгдэхүүнийг угсрах үндэстэн дамнасан корпорацуудын бүтээгдэхүүний эд ангийн зөвхөн нэгийг л үйлдвэрлэдэг жижиг дунд үйлдвэрлэлийг богино хугацаанд амжилттай хөгжүүлж чадсан байна.

Улс орнууд дэдбүцээ байнга боловсронгуй болгож, үйлчилгээний зардлыг бүс нутгийн бусад орнуудаас харьцангуй доогуур тогтоодог байна. Түүнчлэн улс орнууд чөлөөт бүсдээ урамшуулал, хөнгөлөлт үзүүлэхдээ зохион бүтээх туршилтын шийдлийг хөхүүлэн дэмжих, дотооддоо гүн боловсруулалтыг нэвтрүүлэх замаар өндөр ашиг өгөх үйлчилгээ, үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн болон бусад үйлчилгээ өөд тэмүүлэх хөдөлгөөнийг дэмжих талаар онцгой хүчин чармайлт тавьдаг байна.

Улс орон бүр хөгжлийн янз бүрийн шатанд байж, нийгэм-эдийн засгийн тогтолцоо нь байнга өөрчлөгдөж байдаг учраас нэг загварын чөлөөт бүс байгуулж болохгүй нь мэдээж. Монгол Улс “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар төлөвлөхдөө аялал жуулчлал, үйлчилгээ /казиног оролцуулан/, үйлдвэрлэл, худалдаа гэсэн нэг төрлийн бус олон төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг эдийн засгийн чөлөөт бүсийн загварыг сонгож авсан нь судалгааны үндэслэлтэй сонголт болсон гэж үзнэ. Одоо зөвхөн өмнөд хөршийн болон Зүүн хойт Азийн орнуудын стратегийн хөрөнгө оруулагчдийг өөртөө татах талаар дорвитой, шийдэмгий арга хэмжээ авах л үлдлээ.

Энэ бүсийг Дорнын Лас Вегас хэмээн дэлхий дахинаа дуу алдан хүлээн зөвшөөрөх цаг тун холгүй гэдэгт эргэлзэх зүйлгүй.